

(А-ДБ-7) Суралцагч, мэргэжлийн чиглэлээр

ДЭД БҮЛЭГ-4.6: Мэргэжлийн чиглэлээр

Тайлангийн нэр 1: Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын 20... / 20... оны хичээлийн жилийн мэдээ, мэргэжлийн чиглэлээр

Товч нэр: Мэргэжлийн чиглэлээр Код: А-ДБ-7

Үндэслэл: Үндэсний статистикийн хорооны даргын “Маягт, түүнийг нөхөн зааврыг шинэчлэн батлах тухай” 2020 оны 03 сарын 24-ны өдөр А/31 тоот тушаал

Зорилго: Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн мэдээллийг мэргэжлийн чиглэл бүрээр нийт суралцагч, боловсролын түвшин, хүйсээр ялган харах

Тайлант хугацаа: Жил бүрийн 11 сарын 01-ны дотор

Хамрах хүрээ: Дээд боловсролын сургалтын байгууллага(ДБСБ) нь Дээд боловсролын удирдлагын мэдээллийн систем(ДБУМС)-ийн “Суралцагч” модульд суралцагчийн мэдээллийг оруулан тайлан бодуулж баталгаажуулсны дараа Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага(БАЭТЗТБ) тайлан баталгаажуулан Үндэсний статистикийн хороонд ирүүлнэ.

ОН, ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК

ХИЧЭЭЛИЙН ЖИЛ	ТОВЧ НЭР	ТАЙЛАНГИЙН КОД	ТАЙЛАНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ НЭР
2019-2020 оны хичээлийн жил	Аймаг, нийслэл, өмчийн хэлбэр, ангиллаар	3-ДБ-34	ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН 20... / 20... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ, аймаг, нийслэл, дүүргээр

Заавар: (А-ДБ-7) МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

А. Үндсэн мэдээлэл Бүх суралцагчид (багана 1:3) -Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын нийт тоог (багана 1)-т, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй эрэгтэй суралцагчдын тоог (багана 2)-т, эмэгтэй суралцагчдын тоог (багана 3)-т тус тус бичнэ багана1=(2+3).
Дипломын боловсрол (багана 4:6) -Дипломын боловсролд суралцагчдын нийт тоог (багана 4)-т, эрэгтэй суралцагчдын тоог (багана 5)-д, эмэгтэй суралцагчдын тоог (багана 6)-д тус тус бичнэ багана4=(5+6).
Бакалаврын боловсрол (багана 7:9) -Бакалаврын боловсролд суралцагчдын нийт тоог (багана 7)-д, эрэгтэй суралцагчдын тоог (багана 8)-д, эмэгтэй суралцагчдын тоог (багана 9)-д тус тус бичнэ багана7=(8+9).
Магистрын боловсрол (багана 10:12) -Магистрын боловсролд суралцагчдын нийт тоог (багана 10)-т, эрэгтэй суралцагчдын тоог (багана 11)-т, эмэгтэй суралцагчдын тоог (багана 12)-т тус тус бичнэ багана10=(11+12).
Докторын боловсрол (багана 13:15) -Докторын боловсролд суралцагчдын нийт тоог (багана 13)-т, эрэгтэй суралцагчдын тоог (багана 14)-т, эмэгтэй суралцагчдын тоог (багана 15)-д тус тус бичнэ багана13=(14+15).
Бүгд (мөр 1) -Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын улсын хэмжээний нийт дүнг бичнэ.
Үүнээс задалж (мөр 2:26) -Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдыг суралцаж буй мэргэжлийн чиглэлээр (ерөнхий чиглэл, төрөлжсөн чиглэл, нарийвчилсан чиглэл) ангилан гаргана.
Мэргэжлийн чиглэлийн ангиллыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78, 2014 оны А/370, 2015 оны А/138, 2015 оны А/262, 2017 оны А/52, 2019 оны А/336 дугаар тушаалын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад

мөрдөх диплом, бакалавр, магистр, докторын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/ индекс”, ЮНЕСКО-гоос 2013 онд гаргасан “Боловсролын мэргэжлийн чиглэл-ISCED-F” зэрэг баримт бичгийг баримтална. Боловсролын мэргэжлийн чиглэл нь 3 үе шаттай, дээрээс доош буюу ерөнхий чиглэл, төрөлжсөн чиглэл, нарийвчилсан чиглэл гэсэн тогтолцоотой, 4 оронтой тоогоор кодлогдсон байна. 10 ерөнхий чиглэл, 29 төрөлжсөн мэргэжил, 80 орчим нарийвчилсан мэргэжлээр хуваагдсан байна.

Түвшин Чиглэлийн ангилал Чиглэлийн тоо 1-р түвшин Ерөнхий чиглэл 10 2-р түвшин Төрөлжсөн мэргэжил 29 3-р түвшин Нарийвчилсан мэргэжил ≥ 80

Орц: “Суралцагч” модуль Суралцагчийн элсэлт, шилжилт хөдөлгөөн, үндсэн мэдээлэл, сургалтын мэдээлэл, статистик мэдээллийг оруулсны дараа системээр тодорхой дүрмээр бодолт хийж гарна. Модуль: Суралцагч Асуулгын маягт:ДБСБ-ын суралцагчийн асуулгын маягт- АМ-4